



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ  
ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ  
НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ  
ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН  
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

---



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх дунд, богино хугацааны бодлогыг дараах хөтөлбөрүүдэд тусган хэрэгжүүлсэн байна



**БИД ХАМТДАА**

Өмнөговь аймгийг хөгжүүлэх “2016-2020”  
онд хөгжүүлэх “Бид хамтдаа” хөтөлбөр



Өмнөговь аймгийг хөгжүүлэх “2020-2024”  
онд хөгжүүлэх “Нутгийн хишиг” хөтөлбөр



## Орон нутгаас хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, хүрсэн үр дүн

**ТӨСӨВ: 323.0 сая ₮**

**Зорилт, арга хэмжээ:**

1. Зорилтот бүлэгт чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр төслүүдийг шат дараатайгаар хэрэгжүүлэх,
2. "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" хөтөлбөр

2017 ОН

### ХЭРЭГЖСЭН ҮР ДҮН:

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын дунд "Ажилтай иргэн-Орлоготой өрх" ажлын хүрээнд 52 аж ахуйн нэгж оролцон 815 иргэн шинэ ажлын байртай болж, 180 иргэнийг түр ажлын байраар хангасан байна. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих Start-up арга хэмжээг Даланзадгад, Ханбогд суманд зохион байгуулж, 47 залуучуудыг дэмжин ажлын байраар хангажээ.

**ТӨСӨВ: 200.0 сая ₮**

**Зорилт, арга хэмжээ:** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах

2018 ОН

### ХЭРЭГЖСЭН ҮР ДҮН:

"Оюу толгой" ХК 62 иргэнийг ажлын байраар хангажээ. Мөн ажлын байранд зуучлах, сургалт зохион байгуулж, 754 иргэнийг ажлын байранд зуучлан, 415 иргэнийг түр ажлын байраар хангасан байна.

**ТӨСӨВ: 150.0 сая ₮**

**Зорилт, арга хэмжээ:** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах

2019 ОН

### ХЭРЭГЖСЭН ҮР ДҮН:

Аймгийн төвүүдийн томоохон компаниудыг оролцуулан 90 иргэнийг ажлын байраар хангасан байна. 2019 оны байдлаар бүлгийн сургалтыг 351 хүнд зохион байгуулж, шинэ ажлын байранд 1003 хүн, түр ажлын байранд 50 иргэн, өссөн дүнгээр 720 хүн ажилд зуучлагдсан байна.

**ТӨСӨВ: 280.0 сая ₮**

**Зорилт, арга хэмжээ:** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах

2020 ОН

### ХЭРЭГЖСЭН ҮР ДҮН:

Өрх гэр бүлийн хөгжлийн жилийн хүрээнд "Нэг өрх-нэг ажлын байр" программыг нэвтрүүлэн зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэх боломжтой 130 иргэнийг ПТК-той хамтран үсчин, тогооч, оператор, хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн, гагнуурчин, оёдолчин зэрэг 11 төрлийн мэргэшүүлэх сургалтад хамруулан түр болон байнгын ажлын байранд 1292 иргэд оржээ.

**ТӨСӨВ:**

**Зорилт, арга хэмжээ:** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах


2021 ОН

### ХЭРЭГЖСЭН ҮР ДҮН:

Газар тариалан эрхлэх хүсэлтэй иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 38 хүлэмжийг иргэдэд 50 хувийн хөнгөлөлттэй олгосон байна. Аймгийн хэмжээнд шинэ ажлын байр 1103, түр ажлын байраар 127 хүн хангагдаж 910 хүн ажлын байранд зуучлагдсан байна.



## Хөдөлмөрийн зах зээлийн статистик мэдээ





ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ  
ГАЗАР**

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын тушаалаар баталсан маягтын дагуу өмнөх оны батлагдсан төсөв, зардлын гүйцэтгэлд суурилан төсвийн төслийг боловсруулдаг байна.



Санхүүжилтийн эх үүсвэрийг тооцоолсон суурь судалгаа, тооцоолол байхгүй байна.



**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМ**

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл нь тухайн оны төсвийн саналыг нэгтгэн хэлэлцэж, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газраар дамжуулан аймаг, нийслэл, дүүрэгт хуваарилдаг байна.



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байрыг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд 2016-2021 онд 5,034.2 сая төгрөгийг олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 4,703.7 сая төгрөгийг олгон 330.5 сая төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ  
ГАЗАР**



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**

Аймгийн Засаг даргын 2018 оны А/347, 2021 оны А/1151 дугаар захирамжуудаар аймгийн хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний Ерөнхий газраас 2018 онд хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хяналт, мониторингийн шалгалт хийж, дараах зөвлөмжийг өгсөн байна.

Аймгийн Хөдөлмөр хөлөмж үйлчилгээний газарт хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн удирдамжийн дагуу хяналт хийж тайлан бичиж байгаа боловч алдаа зөрчлийг нэгтгэсэн хүснэгт, дүн шинжилгээ, судалгаа байхгүй байна.

Тус салбар зөвлөлд Гэр бүл, залуучууд хөгжлийн газраас төлөөлөл оруулаагүй байна.

Төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтийг нь удирдан зохицуулах, биелэлтэд нь хяналт тавих, төслийн үр дүн нөлөөлөлд жил бүр үнэлгээ хийж, санал дүгнэлт гаргаагүй байна.

- Төсөл хөтөлбөрийн эргэн төлөлтөд хяналт тавин гэрээнд заасан хугацаанд багтаан төлүүлж байх,
- Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд явцын болон гүйцэтгэлийн хяналтыг тогтмол хийж, үр дүн үр нөлөөг тооцон хэрэгжээгүй төсөл арга хэмжээг буцаан татаж сангийн хөрөнгийн үр ашигтай байдлыг сайжруулахад анхаарч ажиллах,
- Төсөл хөтөлбөрийг сонгон шалгаруулахдаа зохих хууль журмын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй зохион байгуулах.



Зөрчил гаргаж байгаа этгээдэд холбогдох хууль журмын дагуу хариуцлага тооцдоггүй, зээлийг эргүүлэн татах талаар ямар нэгэн арга хэмжээ авдаггүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хөндлөнгийн байгууллагаар 2017-2021 онд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгээгүй байна.



	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
Ажилд жуучлах үйлчилгээ	Хамрагдсан иргэд <b>806</b>	Хамрагдсан иргэд <b>770</b>	Хамрагдсан иргэд <b>918</b>	Хамрагдсан иргэд <b>1,235</b>	Хамрагдсан иргэд <b>1,049</b>	Хамрагдсан иргэд <b>798</b>
	Олгосон санхүүжилт <b>3.6 сая ₮</b>	Олгосон санхүүжилт <b>10.2 сая ₮</b>	Олгосон санхүүжилт <b>9.1 сая ₮</b>	Олгосон санхүүжилт <b>7.5 сая ₮</b>	Олгосон санхүүжилт <b>1.5 сая ₮</b>	Олгосон санхүүжилт <b>2.2 сая ₮</b>
Ажилд жуучлах үйлчилгээ	Хамрагдсан иргэд <b>825</b>	Хамрагдсан иргэд <b>938</b>	Хамрагдсан иргэд <b>1,100</b>	Хамрагдсан иргэд <b>1,550</b>	Хамрагдсан иргэд <b>618</b>	Хамрагдсан иргэд <b>333</b>
	Олгосон санхүүжилт <b>9.9 сая ₮</b>	Олгосон санхүүжилт <b>7.8 сая ₮</b>	Олгосон санхүүжилт <b>9.2 сая ₮</b>	Олгосон санхүүжилт <b>10.8 сая ₮</b>	Олгосон санхүүжилт <b>4.7 сая ₮</b>	Олгосон санхүүжилт <b>5.0 сая ₮</b>





Шинээр бий болж байгаа ажлын байрны зарыг ААН, байгууллагуудаас сар бүр авч вэб сайт, фэйсбүүк групп, салбар агентлаг, орон нутгийн телевизүүдээр мэдээлдэг байна



Вэб сайт [/http://omnogovi.hudulmur-halamj.gov.mn/](http://omnogovi.hudulmur-halamj.gov.mn/)



Орон нутгийн телевиз  
“Алтанговь” ТВ



Фэйсбүүк зарын групп  
[/www.facebook.com/Omnogovi.HHUGazar/](http://www.facebook.com/Omnogovi.HHUGazar/)



**ГОВИЙН  
НАРАН**  
ТЕЛЕВИЗ

Орон нутгийн телевиз  
“Говийн наран” ТВ



Орон нутаг дахь агентлаг  
“МОНЦАМЭ” агентлаг




Орон нутгийн телевиз  
“USTV” ТВ






Хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлсэн байдал:



Хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлсэн байдал:



Ганцаарчилсан сургалтад хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо:



2018 он 41%  
2019 он 52%  
2020 он 56%  
2021 он 36%

Бүлгийн сургалтад хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо:



2018 он 0%  
2019 он 60%  
2020 он 65%  
2021 он 65%



Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн үр ашгийг тооцож, тайлагнадаг байна



Нийт 81.5 сая төгрөгийг 2016-2021 онд зарцуулсан байна.



Нийт 10940 иргэн хамрагдсан байна.



Нийтлэг үйлчилгээний жишиг зардлыг Нийгэм хамгаалал хөдөлмөрийн сайдын тушаалаар жил бүр баталсан байна.



ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ

Орон нутагт шинээр бий болсон ажлын байрны мэдээг гаргуулан авч хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн санд бүртгэж ажилласан байна.



THE WORLD BANK

Дэлхийн банкны санхүүжилтээр “Бичил бизнесийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна



Нийт 34 иргэнд 12 чиглэлээр 313.0 сая төгрөгийн зээл олгосон байна.



Шинээр 63 ажлын байр нэмэгдсэн байна.



Дэлхийн банкнаас тогтоосон зээл олгох шалгуур үзүүлэлтийн дагуу ХХҮГ-аас арилжааны банк руу хүсэлт хүргүүлсэн байна.



Зээлийг Хаан банкаар дамжуулан жилийн 7.2 хувийн хүүтэй 24 сарын хугацаатайгаар олгосон байна. Тавигдах шаардлага өндөр байдаг нь иргэдэд хүндрэлтэй, хамрагдах хүний тоо цөөн байдаг байна.





## Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр



Нийт 185.0 сая төгрөгийг 2017-2021 онуудад санхүүгийн дэмжлэг болгон олгожээ.



Нийт 28 иргэн хамрагдсан байна.



Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, үйл ажиллагаа явуулаагүй 7 иргэний 22.7 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна.



Зарим төсөл хэрэгжүүлэгч зээлийг зориулалтын дагуу дагуу үр ашигтай ашиглан хэрэгцээтэй тоног төхөөрөмж худалдан авч, шинээр ажлын байр бий болгосон сайн талтай байна.



Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2016-2021 онуудад 196 иргэнд 898.7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна.



Нийт 898.7 сая төгрөгийг 2016-2021 онуудад санхүүгийн дэмжлэг олгосон байна.



Нийт 196 иргэн хамрагдсан байна.



Анх 15-39 насныхан хамрагддаг байсан бол 2019 оноос өөрчлөлт орж 15-45 насны иргэд хамрагдахаар болсон байна.



Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхүүд 11980 толгой мал худалдан авсан байна.



### Шилдэг Start-up залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох хөтөлбөр:

Тус хөтөлбөрийн хүрээнд 2021 онд гэрлийн дулаанаар хүнсний ногоо тариалах чиглэлээр төсөл шалгаруулан 10.0 сая төгрөгийн эргэн төлөлтгүй дэмжлэг үзүүлсэн байна.



Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар зохион байгуулсан арга хэмжээ байхгүй байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 46.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.



### Орон нутгийн онцлогт тохирсон төсөл:

Уг хөтөлбөрийн хүрээнд Цогт-Овоо сумын “Монсор Илч” ХХК-ны хонины нэхий боловсруулах үйлдвэрлэлийн төслийг сонгон шалгаруулж 100.0 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэгийг 3 жилийн хугацаанд эргэн төлөгдөхөөр олгосон байна.



### Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр:

Санхүүжилт  
92.5 сая ₮



- 31 Тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа
- 3 Улирлын чанартай үйл ажиллагаа явуулж байгаа
- 12 Үйл ажиллагаа явуулахгүй байгаа

### Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр:

Санхүүжилт  
225.0 сая ₮



- 51 Тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа
- 16 Улирлын чанартай үйл ажиллагаа явуулж байгаа
- 27 Үйл ажиллагаа явуулдаггүй, үйл ажиллагаа нь зогссон

### 35-аас дээш насны иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр:

Санхүүжилт  
724.1 сая ₮




- 136 Тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа
- 22 Улирлын чанартай үйл ажиллагаа явуулж байгаа
- 59 Үйл ажиллагаа явуулдаггүй, үйл ажиллагаа нь зогссон




**Өмнөговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого**

/сая төгрөг/



**ХЭДС-ийн хөрөнгийн төсвийн гүйцэтгэл 2016-2021 онуудыг нэгтгэсэн байдлаар**





Өмнөговь аймгийн ажилгүйдлийн түвшин, хөдөлмөр эрхлэлтийг сүүлийн 6 жилээр харуулбал дараах байдалтай байна

Ажилгүйдлийн түвшин ба хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

/хувиар/

 Огноо	 Ажилгүйдлийн түвшин	 Хөдөлмөр эрхлэлт
2016 он	 14.3	 59.1
2017 он	 16.4	 57.5
2018 он	 7.3	 64.0
2019 он	 6.0	 66.7
2020 он	 5.6	 67.8
2021 он	 6.0	 57.5



Мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагаас хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн байна

Өмнөговь аймгийн Политехникийн коллежийн мэргэжлийн боловсрол олгосон байдал



 Огноо	 Төгсөгчдийн тоо
2016 он	175
2017 он	346
2018 он	98
2019 он	155
2020 он	194
2021 он	279



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн хөнгөлөлт, чөлөөлөлт нь аж ахуй нэгж, иргэдэд дэмжлэг болсон байна

Нийгмийн даатгалын хөнгөлөлт, чөлөөлөлтийн байдал

/сая төгрөг/

ОГНОО	Хамрагдсан ААН-ий тоо	Чөлөөлөгдсөн дүн
2020 он	↑ 726	↑ 24,407.5
2021 он	↑ 796	↓ 6,167.2



ХХҮГ-ын доорх мэдээллүүд нь аймгийн Статистикийн хэлтсийн мэдээллүүдтэй тохирч байна

Цар тахлын үеийн хөдөлмөрийн зах зээлийн статистик

№	Үзүүлэлт	2020 он	2021 он
1	15 ба түүнээс дээш насны хүн амын тоо	48010	48650
2	Ажиллах хүч	30175	28119
3	Ажиллах хүчний гадуурх хүн ам	11813	17893
4	Ажиллагсдын тоо	28473	26434
5	Ажилгүй иргэдийн тоо	4823	4568
6	Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо	652	703
7	Ажлын шинэ байр	1385	1103
8	Ажилгүйдлийн түвшин	5.6	6.0
9	Хөдөлмөр эрхлэлт (хувиар)	67.8	57.5



ДҮГНЭЛТ: ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.